



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2017.08.15

Улаанбаатар хот

1


САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

1.1 ЕРӨНХИЙ ТӨЛӨВ БАЙДАЛ

2017 оны эхний хагас жилийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх ББСБ-уудын тоо 533-д хүрснээр өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар, оны эхнээс 2.9 хувиар, өмнөх улирлаас 0.8 хувиар тус тус өслөө.

(Дүрслэл 1.1)

Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо



Банк бус санхүүгийн байгууллагуудын тооны өсөлтөд арилжааны банкуудын зээлийн нөхцөл чангарсан, иргэд, аж ахуйн нэгж байгууллага шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээ ББСБ-уудын бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан авах эрэлт хэрэгцээ нэмэгдсэн, хөрөнгө оруулагчид банк бус санхүүгийн салбарт хөрөнгө оруулах сонирхол бий болсон зэрэг хүчин зүйлс нөлөөлөв.

Хүснэгт 1.1

Тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017-П
Шинээр олгосон	20	32	23	54	120	80	72	20
Хүчингүй	15	19	6	3	5	8	4	5
Түдгэлзүүлсэн	20	14	4	3	5	6	-	17
Сэргээсэн	7	8	2	1	1	5	1	-
Нийт ББСБ	182	195	212	263	378	450	518	533

2017 оны тайлант улиралд Хорооны хуралдаанаар 20 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 5 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгох, 17

ББСБ-уудын 2017 оны нэгдүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Тайлант улирлын байдлаар Хорооны хуралдаанаар нэр бүхий 8 ББСБ-д үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгох, 1 ББСБ-ын зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1.2

Тусгай зөвшөөрөл нэмж олгосон үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны төрөл	ББСБ тоо	
		2016-П	2017-П
1	Зээл	2	2
2	Гадаад валютын арилжаа	2	1
3	Факторингийн үйлчилгээ	-	1
4	Цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга	4	1
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	1	-
6	Төлбөрийн баталгаа гаргах	1	-
7	Итгэлцлийн үйлчилгээ	-	-
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	-	4
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	-	1

Хүчингүй болгосон үйл ажиллагааны нэр төрөл

1	Зээл	1	1
---	------	---	---

Түүнчлэн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаж ажиллаагүй 17 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 1 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хорооны санаачлагаар, 4 ББСБ үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг өөрийн хүсэлтээр хүчингүй болгосон байна.

2017 оны хоёрдугаар улирлын байдлаар давхардсан тоогоор нийт ББСБ-ын 90.1 хувь буюу 480 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 27.6 хувь буюу 147 ББСБ гадаад валютын арилжаа, 5.8 хувь буюу 31 ББСБ хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 5.1 хувь буюу 27 ББСБ итгэлцлийн үйлчилгээ, 4.1 хувь буюу 22 ББСБ факторингийн үйлчилгээ, 3.2 хувь буюу 17 ББСБ төлбөрийн баталгаа гаргах, 2.6 хувь буюу 14 ББСБ цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 1.1 хувь буюу

6 ББСБ богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, 0.4 хувь буюу 2 ББСБ төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээг тус тус эрхэлж байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан эрхлэх үйл ажиллагааны төрлөөр ББСБ-уудыг ангилвал:

Хүснэгт 1.3

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны тоо

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ББСБ-ын тоо		Өсөлт	
		2016-И	2017-И	тоо	хувь
Нийт ББСБ		499	533	34	6.8
1	Зээлийн үйл ажиллагаа	443	480	37	8.4
<i>Үүнээс: Зээлийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг</i>		324	357	33	10.2
2	Факторонгийн үйлчилгээ	22	22	-	-
3	Төлбөрийн баталгаа гаргах	16	17	1	6.3
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	1	2	1	2 дахин
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	12	14	2	16.7
6	Гадаад валютын арилжаа	142	147	5	3.5
<i>Үүнээс: Гадаад валютын арилжаа дагнан эрхэлдэг</i>		51	53	2	3.9
7	Игэлцлийн үйлчилгээ	28	27	-1	(3.6)
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	6	4	3 дахин
9	Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх	33	31	-2	(6.1)

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааны төрлөөс нийт ББСБ-ын 67 хувь буюу 357 ББСБ зээлийн үйл ажиллагааг дагнан эрхэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 33 компаниар буюу 10.2 хувиар, оны эхнээс 14 компаниар буюу 4.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2017 оны хоёрдугаар улирлын байдлаар Хорооны даргын тушаалаар 219 ББСБ хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж, 67 ББСБ хаяг, байршил, 48 ББСБ гүйцэтгэх удирдлагын өөрчлөлтийг Хороонд бүртгүүлсэн байна.

Энэ онд тусгай зөвшөөрөл шинээр авсан 20 банк бус санхүүгийн байгууллагын 6 нь хөдөө орон нутагт байгуулагдсан ба 18 ББСБ нь зээлийн үйл ажиллагааг дагнан эрхэлж байна.

Хүснэгт 1.4

Тусгай зөвшөөрөл шинээр олгосон ББСБ-уудын мэдээлэл /ХНХ-гэрбум төгрөгөөр/

Байршил	ББСБ тоо	ХНХ	Хувьцаа эзэмшигчдийн тоо
Улаанбаатар хот	14	23.9	18
Хөдөө орон нутаг	6	0.5	11
Нийт	20	24.4	29

Сүүлийн үед бизнесийн идэвхижил саарч, зээлийн чанар муудаж, эргэн төлөлт удааширсантай холбогдуулан зарим банк бус санхүүгийн байгууллагууд Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх сонирхол бий болсон.

1.2. СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2017 оны хоёрдугаар улиралд тайлан мэдээг ирүүлбэл зохих 533 ББСБ-аас 515 ББСБ /96.6%/ зохих ёсоор бүрэн ирүүлснийг холбогдох журмын дагуу хянаж, тайлангийн нэгтгэлд хамруулсан бөгөөд харин дор дурдсан нэр бүхий 18 ББСБ эхлэлтийн тайлан тэнцлээр болон өмнөх үеийн санхүүгийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдлаа. Үүнд:

Хүснэгт 1.5

Эхлэлтийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан ББСБ-ууд

№	ББСБ нэр	ТЗ олгосон огноо	Үйл ажиллагааны төрөл
1	Ти эн эн	2016.05.17	Зээлийн үйл ажиллагаа
2	Монголиан юнайтед кредит	2017.04.12	Зээлийн үйл ажиллагаа
3	Эхлэл капитал	2017.01.13	Зээлийн үйл ажиллагаа
4	Монголиан фاینэншл партнерс	2017.04.12	Зээлийн үйл ажиллагаа
5	Их цалуу	2017.06.07	Зээлийн үйл ажиллагаа
6	Номин гүнж	2017.01.13	Зээлийн үйл ажиллагаа
7	Прайм фاینаншиал холдингс	2017.06.22	Зээлийн үйл ажиллагаа

Өмнөх үеийн тайлан тэнцлээр нэгтгэлд хамрагдсан ББСБ

№	ББСБ нэр	Тайлант үе
1	ББС велт	2017-I
2	Ворлд проспер	2016-IV
3	Дэвжих хөгжил	2017-I
4	Сүлдэт тамган	2017-I
5	Смарт менежмент	2017-I
6	Эс эс эн жи	2016-II
7	Элтизэ	2017-I
8	Сэлементс	2017-I
9	Сакура финанс	2016-IV
10	Сан ундрага	2017-I
11	Та финанс	2016-III

2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 533 ББСБ 126 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. ББСБ-ын тоо өмнөх оны мөн үеэс 34 компаниар нэмэгдэж 533-т, хувьцаа эзэмшигчдийн тоо 63-аар нэмэгдэж 1049-т, салбарт ажиллагсдын тоо 234-өөр нэмэгдэж 2282-т хүрлээ. Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харуулбал:

Хүснэгт 1.6

Ерөнхий статистик үзүүлэлт 1

№	Үзүүлэлтүүд	2016-И		2017-И		Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	дүн	хувь	хувь
1	Нийт ББСБ тоо	499	533	34	6.8		
	Үүнээс: хөдөө орон нутагт	53	66	13	24.5		
2	Харилцагчдын тоо	420,505	1,389,018	968,513	230.3		
	Үүнээс: эмэгтэй	39,805	58,386	18,581	46.7		
	Хуулийн этгээд	1,317	1,590	273	20.7		
3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	986	1,049	63	6.4		
	Үүнээс эмэгтэй	359	367	8	2.2		
4	Ажиллагсдын тоо	2,048	2,282	234	11.4		
	Үүнээс эмэгтэй	1,148	1,235	87	7.6		
5	Салбар нэгжийн тоо	124	126	2	1.6		
	Үүнээс: Улаанбаатар хотод	94	95	1	1.1		
	Үүнээс: хөдөө орон нутагт	30	31	1	3.3		
6	Төлөөлөгчийн газар	4	4	-	-		

ББСБ-уудын харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 968,513-аар буюу 230.3 хувиар өссөн өсөлтөд 1 ББСБ-ын цахим мөнгөний үйлчилгээний харилцагчдын тоо өссөн нь нөлөөлсөн бөгөөд эдгээр нь /1,212,344/ нийт харилцагчдын 87.2 хувийг бүрдүүлж байна. Үлдсэн 176,674 харилцагчдын 65,449 буюу 37 хувийг зээлдэгчид эзэлж байна.

ББСБ-ууд дэвшилтэд технологийг нэвтрүүлэх замаар бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлөө нэмэгдүүлэх, ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай үйлчилгээний чанар, үнээр өрсөлдөх замаар үйлчилгээний хүртээмжээ сайжруулах боломжтой юм.

ББСБ-уудын нийт актив өмнөх оны мөн үеэс 179.3 тэрбум төгрөгөөр өсч 855.8 тэрбум төгрөгт, өөрийн хөрөнгө 174.4 тэрбум төгрөгөөр өсч 681.4 тэрбум төгрөгт, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 160.7 тэрбум төгрөгөөр өсч 549.5 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 1.7

Ерөнхий статистик үзүүлэлт 2

№	Үзүүлэлтүүд	2016-И		2017-И		Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	дүн	хувь	хувь
1	Нийт хөрөнгө	676.5	855.8	179.3	26.5		
2	Нийт зээл	412.1	554.9	142.8	34.7		
3	Нийт өөрийн хөрөнгө	507	681.4	174.4	34.4		
4	Хувьцаат капитал	388.8	549.5	160.7	41.3		
5	Нийт орлого	84.2	89.4	5.2	6.2		

ББСБ-уудын 2017 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга


6	Нийт зарлага	59.2	61.3	2.1	3.5
7	Тайлант үеийн ашиг	25.0	28.1	3.1	12.4

Өмнөх улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт актив банкны салбарын 3.2 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 4.1 хувь, өөрийн хөрөнгө 19.5 хувьтай тус тус тэнцэж байсан.

Жич: Нэгтгэлийн мэдээлэл гаргах үеийн байдлаар банкны салбарын 2017 оны хоёрдугаар улирлын тоон үзүүлэлтүүд гараагүй байсан болно.

(Дүрслэл 1.2)

ББСБ-дын тоон үзүүлэлтүүд



2012 оноос эхлэн Монгол улсын эдийн засаг сэргэж, хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэж, хөрөнгө оруулагчид банк бус санхүүгийн салбарт хөрөнгө оруулах болсноор 2012-2015 оныг хүртэлх хугацаанд ББСБ-уудын тоо жилд дунджаар 75-аар нэмэгдсэн. Үүнээс хойш ББСБ-уудын тоо тогтмол өссөн хэдий ч 2016 оноос өсөлт нь харьцангуй удааширсан байна. ББСБ-уудын тоо, харилцагч үйлчлүүлэгчдийн тоотой шууд хамааралтайгаар өсөхийн хэрээр мөн хэмжээгээр хөдөлмөрийн зах зээлийг дэмжиж, иргэдийн эдийн засагт итгэх итгэл сэргэж байгаа нь дээрх зураглалаас харагдаж байна.

Улсын хэмжээнд 533 ББСБ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаагийн 12.4 хувь буюу 66 нь хөдөө орон нутагт, 87.6 хувь буюу 467 нь банк, санхүүгийн үйлчилгээний төвлөрөл, хүн амын нягтаршлаа дагаад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 33.6 хувь буюу 157 ББСБ нь Чингэлтэй дүүрэгт, 32.8 хувь буюу 153 ББСБ нь Сүхбаатар дүүрэгт төвлөрсөн байгаа бол

харин Багахангай дүүрэгт одоогоор ББСБ байгуулагдаагүй байна.



эрхэлж байгаа ба Орхон, Төв, Дорнод аймгуудад хамгийн их төвлөрсөн байна.

(Дүрслэл 1.3)

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-дын тархалт

(Дүрслэл 1.4)

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын тархалт



Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 66 ББСБ-дын 55 ББСБ буюу 83.3 хувь нь аймгийн төвд, 11 ББСБ буюу 16.7 хувь нь аймгийн төвөөс бусад сумдад үйл ажиллагаа

Он гарсаар Увс аймагт 2 ББСБ, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ, Говь-Алтай аймгуудад тус тус 1 ББСБ үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан байна.

2

АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. АКТИВЫН БҮТЭЦ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

2017 оны хоёрдугаар улирлын байдлаар ББСБ-уудын актив хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Хүснэгт 2.1

(мянган төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ	2016-II		2017-II		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	650,475,384.0	96.1	819,685,596.0	95.8	169,210,212.0	26.0
1	Мөнгөн хөрөнгө	207,821,699.3	30.7	232,837,914.5	27.2	25,016,215.2	12.0
2	Богино хугацаат ХО /цэврээр/	1,273,240.8	0.2	5,451,786.5	0.6	4,178,545.7	328.2
3	Нийт зээл	412,072,970.5	60.9	554,938,800.1	64.8	142,865,829.6	34.7
	(Зээлийн эрсдлийн сан)	33,461,288.1	4.9	47,373,160.4	5.5	13,911,872.3	41.6
4	Нийт факторингийн тооцооны авлага	100,000.0	-	30,000.0	-	(70,000.0)	(70.0)
5	(Факторингийн авлагын эрсдэлийн сан)	30,000.0	-	30,000.0	-	-	-
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	2,743,947.1	0.4	6,011,194.7	0.7	3,267,247.6	119.1
7	Бусад хөрөнгө	59,954,814.4	8.9	67,819,060.7	7.9	7,864,246.3	13.1
B	Эргэлтийн бус хөрөнгө	26,060,291.8	3.9	36,101,688.0	4.2	10,041,396.2	38.5
8	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	32,703,212.4	4.8	43,715,835.3	5.1	11,012,622.9	33.7
	(Хуримтлагдсан элэгдэл)	6,642,920.6	1.0	7,614,147.2	0.9	971,226.6	14.6
НИЙТ ХӨРӨНГӨ		676,535,675.8	100	855,787,284.0	100	179,251,608.2	26.5

Салбарын нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 26.5 хувиар, оны эхнээс 8.7 хувиар өсч, 855.8 тэрбум төгрөгт хүрлээ.


Нийт активын бүтцийг авч үзвэл 95.8 хувийг эргэлтийн хөрөнгө, 4.2 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаагийн 64.8 хувь нь нийт зээлийн өрийн үлдэгдэл, 27.2 хувь нь мөнгөн хөрөнгө, 7.9 хувь нь бусад хөрөнгө байна.

Салбарын активын бүтцийн гол өөрчлөлтүүдийг харвал нийт активт эзлэх зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 142.9 тэрбум төгрөгөөр, богино хугацаат хөрөнгө оруулалт 4.2 тэрбум төгрөгөөр, үүний дотор Засгийн газрын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт 4 тэрбум төгрөгөөр, өмчлөх болон өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө 3.3 тэрбум төгрөгөөр, бусад хөрөнгө 7.9 тэрбум төгрөгөөр, үүний дотор хуримтлуулсан хүүгийн авлага 5.4 тэрбум төгрөгөөр тус тус өслөө.

Нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдлийн 141.4 тэрбум төгрөг буюу 60.8 хувь нь бэлэн мөнгө, 51.7 тэрбум төгрөг буюу 22.2 хувь нь банкинд байршуулсан харилцах, 34.7 тэрбум төгрөг буюу 14.9 хувь нь банкинд байршуулсан хадгаламж хэлбэрээр тус тус байршиж байна.

(Дүрслэл 2.1)

Салбарын активын бүтэц (тэрбум төгрөгөөр)



2.2 ЗЭЭЛИЙН БАГЦЫН ЧАНАР

ББСБ-дын зээлдэгчдийн тоо оны эхнээс 1,000 зээлдэгчээр буурч 65,449-д хүрснээр нийт зээлдэгчдийн 57,541 буюу 87.9 хувь нь

хэвийн, 2,479 буюу 3.8 хувь нь хугацаа хэтэрсэн, 5,429 буюу 8.3 хувийг чанаргүй зээлдэгчид эзэлж байна.

Тайлант улиралд хугацаа хэтэрсэн зээлтэй зээлдэгчдийн тоо оны эхнээс 1,486-өөр буюу 37.5 хувиар чанаргүй зээлтэй зээлдэгчдийн тоо 884-өөр буюу 14 хувиар тус тус буурсан байна.

Хүснэгт 2.2


Ерөнхий статистик үзүүлэлт 2

Үзүүлэлтүүд	дүн	эзлэх хувь
Нийт зээлдэгчдийн тоо	65,449	100
Үүнээс: -Иргэн	64,585	98.7
-Хуулийн этгээд	864	1.3
Нийт зээлдэгчдийн тоо	65,449	100
Хэвийн	57,541	87.9
Хугацаа хэтэрсэн	2,479	3.8
<i>Чанаргүй:</i>	5,429	8.3
-Хэвийн бус	1,129	1.7
-Эргэлзээтэй	1,158	1.8
- Муу	3,142	4.8
Зээлдэгчдийн насжилт	64,585	100
18-35 насны	25,881	40.1
36-45 насны	22,951	35.5
46-55 насны	12,320	19.1
55-аас дээш	3,433	5.3
Зээлдэгчдийн боловсрол	64,585	100
-Дээд	36,284	56.2
-Тусгай дунд	9,897	15.3
-Бүрэн дунд	12,562	19.5
-Дунд	1,747	2.7
-Бага	4,095	6.3

Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 142.9 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 76.7 тэрбум төгрөгөөр өсч, 554.9 тэрбум төгрөгт хүрлээ.

(Дүрслэл 2.2)

Зээлийн болон активын жилийн өсөлт (хувиар) (2013.II-2017.II)



Нийт зээлийн 518.8 тэрбум төгрөг буюу 93.5 хувь нь төгрөгийн, 36.2 тэрбум төгрөг буюу 6.5 хувь нь валютаар олгосон зээл байна.

Төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 144.9 төгрөгөөр буюу 38.8 хувиар өссөн бол валютаар олгосон зээлийн хэмжээ 2 тэрбум төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Энэ нь банкны салбарын зээлийн нөхцөл чангарсан, эдийн засгийн идэвхижил удааширсан, банкууд зээлээ хумьсан зэрэг хүчин зүйлс нөлөөлөв.

2014 оны хоёрдугаар улиралд зээлийн жилийн өсөлт өмнөх оныхоо мөн үеэс 50.6 хувиар өсөөд байсан бол 2015 оноос эхлэн өсөлт нь харьцангуй удааширч 2017 оны хоёрдугаар улиралд 34.7 хувьд хүрлээ.

Нийт зээлийн үлдэгдлийн 81.1 хувийг хугацаандаа байгаа зээл, 5.9 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 13 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.

Хүснэгт 2.3

Зээлийн чанар (тэрбум төгрөгөөр)

№	Ангилал	2016-II	2017-II	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Хэвийн	330.9	449.8	118.9	35.9
2	Хугацаа хэтэрсэн	32.1	32.9	0.8	2.5
	Чанаргүй зээл:	49.1	72.2	23.1	47.0
3	Хэвийн бус	14.1	12.5	(1.6)	(11.3)
	Эргэлзээтэй	12.2	18.1	5.9	48.4
	Муу	22.8	41.6	18.8	82.5
4	(Зээлийн эрсдэлийн сан)	33.5	47.4	13.9	41.5
Нийт зээл		412.1	554.9	142.8	34.7
1	Үүнээс: Төгрөгийн	373.9	518.7	144.8	38.7
2	Гадаад валютын	38.2	36.2	(2.0)	(5.2)


Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нь банкны салбарын үзүүлэлтээс 2.3 хувиар өндөр байна.

Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 47 хувиар, оны эхнээс 21.5 хувиар өслөө. Учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах санд хуримтлуулсан хөрөнгийн хэмжээ нийт чанаргүй зээлийн 65.7 хувьтай тэнцэж байна.

Нийт төгрөгөөр олгосон зээлийн 12.2 хувь, валютаар олгосон зээлийн 24.9 хувь нь чанаргүй ангилалд шилжсэн байна.

Дүрслэл 2.3


Төгрөгийн зээл, валютын зээлийн харьцаа (мөнгөн дүнгээр)



Эдийн засгийн хямралтай холбоотойгоор иргэд, хувийн хэвшлийн ашиг, орлого буурч байгаа нь зээлийн эргэн төлөлт удааширч, зээлийн чанар муудахад хүргэж байна.

Дүрслэл 2.4

Зээлийн чанар (хувиар)



Сүүлийн 5 жилийн дүн мэдээнээс харахад нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хэмжээ 2013 оны мөн үеэс 11.5 хувиар буурч, чанаргүй зээлийн хэмжээ 9.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант улиралд зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 480 ББСБ-уудаас 25 ББСБ тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг огт эрхлээгүй байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 221.8 тэрбум төгрөг буюу 40 хувийг нэр бүхий 18 ББСБ-ийн зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байна.

Хүснэгт 2.4

Зээлийн өрийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр)		
Интерваль	ББСБ тоо	дүн
11.0-22.8 тэрбум төгрөг хүртэл	11	172.6
5.0-9.0 тэрбум төгрөг хүртэл	8	54.4
1.0-4.9 тэрбум төгрөг хүртэл	97	180.0
0.5-0.9 тэрбум төгрөг хүртэл	147	107.1
0.4 тэрбум төгрөгөөс доош	192	40.8
Үйл ажиллагаа эрхлээгүй	25	-
НИЙТ	480	554.9

Түүнчлэн зээлийн өрийн үлдэгдэл нь 100% чанаргүй ангилалд ангилагдсан нэр бүхий 3 ББСБ-ын 3.1 тэрбум төгрөгийн зээл, 72.9-95.1 хувь нь чанаргүй ангилалд ангилагдсан нэр бүхий 13 ББСБ-ын 12.9 тэрбум төгрөгийн зээлийн эргэн төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, компанийн гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын зөв, оновчтой тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 2.5

ББСБ-уудын зээлийн чанар (тэрбум төгрөгөөр)		
Зээлийн чанар	ББСБ тоо	Дүн
100% чанаргүйдсэн	3	3.1
70-95% чанаргүйдсэн	13	12.9
40-69% чанаргүйдсэн	28	22
10-39% чанаргүйдсэн	95	23.1
0.1-9.9% чанаргүйдсэн	126	11
Чанаргүй зээлийн ангилалд шилжээгүй	190	0.07
Үйл ажиллагаа эрхлээгүй	25	-
НИЙТ	480	72.2

2.3. ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ

2017 оны эхний хагас жилийн байдлаар нийт 314.3 тэрбум төгрөгийн зээл олгож, үүнээс 236.8 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, нийт зээлийн өрийн үлдэгдэл 554.9 тэрбум төгрөг байна. /Тайлант оны эхний үлдэгдэл 477.4 тэрбум төгрөг байсан/

Нийт зээлийн үлдэгдлийн 114.3 тэрбум төгрөг буюу 20.6 хувийг хувийн хэвшилд, 440.6 тэрбум төгрөг буюу 79.4 хувийг иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл эзэлж байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл шинээр олгосон зээлийн 45.5 хувь буюу 142.9 тэрбум төгрөг нь хэрэглээний, 22.2 хувь буюу 69.9 тэрбум төгрөг нь худалдааны салбар, 11.3 хувь буюу 35.6 тэрбум төгрөг нь барилгын салбар, 3.8 хувь буюу 12 тэрбум төгрөг нь уул уурхайн салбар, 3.3 хувь буюу 10.3 тэрбум төгрөг нь боловсруулах

үйлдвэрлэлийн салбар, үлдэх 22.7 хувь буюу 71.4 тэрбум төгрөг нь бусад салбаруудад тус тус олгогдсон байна.

Нийт олгосон зээлийн эргэн төлөлтийг эдийн засгийн гол салбараар авч үзвэл хэрэглээний зээлээс 106.1 тэрбум төгрөг, худалдааны салбараас 56.1 тэрбум төгрөг, барилгын салбараас 31.3 тэрбум төгрөг, уул уурхайн салбараас 5.6 тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэлийн салбараас 6.3 тэрбум төгрөг, бусад салбараас 31.4 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн байна.

Дүрслэл 2.5

Олгосон зээл (зориулалтаар) (хувиар)



Иргэдэд олгосон зээлийн 49.9 хувь буюу 132.3 тэрбум төгрөгийг хэрэглээний, 22 хувь буюу 58.3 тэрбум төгрөгийг худалдааны салбар, 10 хувь буюу 26.4 тэрбум төгрөгийг барилгын салбарт олгосон зээл эзэлж байгаа бол хуулийн этгээдэд олгосон зээлийн 23.5 хувь буюу 11.6 тэрбум төгрөгийг худалдааны салбар, 21.5 хувийг хэрэглээ, 18.6 хувь буюу 9.2 тэрбум төгрөгийг барилгын салбар тус тус эзэлж байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 230.1 тэрбум төгрөг буюу 41.5 хувийг хэрэглээний зээл, 118.7 тэрбум төгрөг буюу 21.4 хувийг худалдааны салбар, 91.3 тэрбум төгрөг буюу 16.4 хувийг барилгын салбар, 23.8 тэрбум төгрөг буюу 4.3 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 21.5 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг уул уурхайн салбар, үлдэх 69.6 тэрбум төгрөг буюу 12.5 хувийг бусад салбар тус тус эзэлж байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 255.2 тэрбум төгрөг буюу 46 хувь нь худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, уул уурхайн гэсэн 4 салбарт төвлөрч байгаа нь эдгээр салбаруудад

хүндрэл үүсэхэд салбарын зээлийн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Дүрслэл 2.6

Нийт зээлийн үлдэгдэл (зориулалтаар) (хувиар)



Салбарын хэмжээнд иргэдэд олгосон зээлийн дээд хүү 10 хувь, доод хүү 0.2 хувь, хувийн хэвшилд олгосон зээлийн дээд хүү 7 хувь, доод хүү 0.5 хувь байх ба салбарын ангиллаар авч үзвэл худалдаа, барилга, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбаруудад зээлийн хүү өндөр байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 480 ББСБ-дын сарын жигнэсэн дундаж хүү 3.5 хувь байна. Энэ нь өмнөх улирлаас 0.6 функтээр буурсан үзүүлэлт бөгөөд банкны салбарын хүүтэй харьцуулахад 1.8 хувиар өндөр байна.

Зарим ББСБ-дын зээлийн хүү өндөр байгаа нь иргэд, хувийн хэвшилд өрийн дарамт үүсгэх, эргэн төлөлт удааширах, эргээд зээлийн чанар муудах эрсдэлийг дагуулж байна.

Зээлийн хүүг бууруулахад гаднаас хямд өртөгтэй эх үүсвэр татах, үйл ажиллагааны зардлаа бууруулах, төсөл, хөтөлбөрийн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, чанаргүй зээлийн эрсдэлтэй холбогдох хууль эрх зүйн орчныг сайжруулах, татварын бодлогоор дэмжих, инфляцийг бага түвшинд тогтвортой барих зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

2.4 АКТИВЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

Тайлант улиралд 25 ББСБ богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд 5.5 тэрбум төгрөг байршуулсны 4 тэрбум төгрөгийг 11 ББСБ-ын Засгийн газрын үнэт цаасанд хийсэн

хөрөнгө оруулалт, 1.5 тэрбум төгрөгийг 17 ББСБ-ын хувьцаагаарх хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс болон оны эхнээс 4.1 тэрбум төгрөгөөр буюу 3.2 дахин өссөн үзүүлэлт юм.

Салбарын хэмжээнд Засгийн газрын үнэт цаасанд 20.0-1,111.2 сая хүртэлх төгрөгийг байршуулсны 77.6 хувийг 1 компанийн хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлж байгаа бол хувьцаагаарх хөрөнгө оруулалтад 1.0-1,169.9 сая хүртэлх төгрөг байршуулсны 77.8 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг 1 компанийн хувьцаагаарх хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлж байна.

Хүснэгт 2.6

Богино хугацаат хөрөнгө оруулалт

БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ЦЭВРЭЭР)	2016- II	2017- II	Өөрчлөлт	
			дүн	хувь
Арилжааны үнэт цаас	0.1	3.5	3.4	35 дахин
Засгийн газрын	-	3.1	3.1	100
Хувьцаа	0.1	0.1	(0.0)	-
Өрийн бичиг	-	0.2	0.2	100
Хөрөнгө оруулалтын үнэт цаас	1.2	2.1	0.9	76.0%
Засгийн газрын	-	0.9	0.9	100
Хувьцаа	1.2	1.2	0.0	0.3%
Үнэт цаасны хорогдуулаагүй нэмэгдэл, хямдруулалт	-	(0.1)	(0.1)	-
НИЙТ	1.3	5.5	4.1	4.2 дахин

2017 оны хоёрдугаар улирлын байдлаар нэр бүхий 1 ББСБ-ын факторингийн тооцооны авлага 30.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 100 хувь эрсдэлийн сан байгуулсан байна. Тус компани авлагын эрсдэлийн санг 2015 оны хоёрдугаар улиралд байгуулсан хэдий ч "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын дагуу шат дараалсан арга хэмжээг авахгүйгээр тайлан тэнцэлд тусгасаар байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 533 ББСБ нь 43.7 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөд 7.6 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байх ба нийт ББСБ-ын 224 ББСБ нь санхүүгийн програмтай байна.

Хүснэгт 2.7

Үндсэн хөрөнгө (тэрбум төгрөгөөр)

Үзүүлэлт	2016-II	2017-II	Өөрчлөлт	
			дүн	хувь
Үндсэн хөрөнгө (цэврээр)	26.1	36.1	10.0	38.5
Үндсэн ба биет бус хөрөнгө	32.7	43.7	11.0	33.7
Биет бус хөрөнгө	3.5	4.1	0.6	15.8
Хуримтлагдсан элэгдэл	6.6	7.6	1.0	14.6

Барилга байгууламж	0.6	0.9	0.3	45.9
Техник хэрэгсэл	4.5	4.8	0.3	6.7

Тавилга эд хогшил	1.6	2.0	0.4	25.4
-------------------	-----	-----	-----	------

3

ПАССИВЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН, ӨӨРЧЛӨЛТ

3.1 ПАССИВЫН БҮТЭЦ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

2017 оны хоёрдугаар улирлын байдлаар ББСБ-дын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 3.1

(мянган төгрөгөөр)

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	2016-II		2017-II		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
A	Нийт өр төлбөр	169,494,675.5	25.1	174,380,935.7	20.4	4,886,260.2	2.9
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	26,747,511.1	4.0	34,545,260.5	4.0	7,797,749.4	29.2
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	101,918,060.8	15.1	92,052,052.5	10.8	(9,866,008.3)	(9.7)
3	Бусад эх үүсвэр	3,035,058.9	0.4	3,525,292.2	0.4	490,233.3	16.2
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	1,506,548.3	0.2	4,313,929.0	0.5	2,807,380.7	186.3
5	Төслийн зээлийн санхүүжилт	20,057,341.6	3.0	16,307,640.3	1.9	(3,749,701.3)	(18.7)
6	Бусад өр төлбөр	16,230,154.8	2.4	23,636,761.2	2.8	7,406,606.4	45.6
B	Өөрийн хөрөнгө	507,041,000.3	74.9	681,406,348.3	79.6	174,365,348.0	34.4
9	Хувьцаат капитал	388,843,755.4	57.5	549,479,575.6	64.2	160,635,820.2	41.3
10	Бусад өмч	8,691,227.4	1.3	8,245,792.5	1.0	(445,434.9)	(5.1)
11	Сангууд	488,155.8	0.1	596,419.5	0.1	108,263.7	22.2
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	108,214,105.9	16.0	122,378,005.4	14.3	14,163,899.5	13.1
13	Хоёрдогч өглөг	803,755.8	0.1	706,555.3	0.1	(97,200.5)	(12.1)
	НИЙТ ПАССИВ ХӨРӨНГӨ	676,535,675.8	100	855,787,284.0	100	179,251,608.2	26.5

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын нийт өр төлбөрийн хэмжээ 2017 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар өсч 174.4 тэрбум төгрөгт хүрлээ. Өр төлбөрийн өсөлтөд итгэлцлийн үйлчилгээний өглөг 7.8 тэрбум төгрөгөөр, ББСБ-аас гаргасан хаалттай өрийн бичиг 2.8 тэрбум төгрөгөөр, бусад өр төлбөр 7.4 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлөв.


Харин өөрийн хөрөнгийн өсөлтөд хувь нийлүүлсэн хөрөнгө 160.6 тэрбум төгрөгөөр өсч, 549.5 тэрбум төгрөгт, хуримтлагдсан ашиг 14.2 тэрбум төгрөгөөр өсч, 122.4 тэрбум төгрөгт хүрсэн нь голчлон нөлөөлжээ.

Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгийн 174.4 тэрбум төгрөг буюу 20.4 хувийг бусдаас татсан эх үүсвэр, 681.4 тэрбум төгрөг буюу 79.6 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаагийн 64.2 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 14.3 хувийг

хуримтлагдсан ашиг, 10.8 хувийг банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 4 хувийг итгэлцлийн үйлчилгээний өр, үлдсэн хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна. 2017 оны тайлант улирлын байдлаарх нийт өр төлбөр 2015, 2016 оны мөн үетэй харьцуулахад харгалзан 6.5 хувь, 2.9 хувийн бууралттай байгаа бол өөрийн хөрөнгө харгалзан 85.2 хувь, 34.4 хувийн өсөлттэй байна.

Дүрслэл 3.1

Пассивын бүтэц (тэрбум төгрөгөөр)




2013-2015 оныг хүртэлх хугацаанд ББСБ-дын өр төлбөр нийт хөрөнгийн 35.7 хувь орчмыг бүрдүүлж байсан бол 2016 оноос эхлэн буурч, 2017 оны хоёрдугаар улиралд 20.4 хувьд хүрлээ. Нийт өр төлбөрийн 52.8 хувийг банк, санхүүгийн байгууллагад төлөх өр төлбөр эзэлж байгаагийн 50.6 хувь нь богино хугацаат, 49.4 хувь нь урт хугацаат зээл ба үүнээс 55.4 тэрбум төгрөг нь төгрөгийн, 36.6 тэрбум төгрөг нь валютын зээл байна.

Нийт өр төлбөрийн бууралтад банк санхүүгийн байгууллагад төлөх өр, төслийн зээлийн санхүүжилтын өр буурсан нь голчлон нөлөөлөв.

Дүрслэл 3.2

Өр төлбөр, өөрийн хөрөнгийн өөрчлөлт (хувиар)



Хорооноос хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, үе шаттай нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн нь ББСБ-дын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өсөхөд тодорхой түлхэц өгч байна. Тухайлбал 2017 онд тусгай зөвшөөрөл олгосон 20 ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө 24.4 тэрбум төгрөг нь нийт өсөлтийн 15.2 хувь, тайлант улиралд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн ББСБ-уудын хөрөнгө болох 83.4 тэрбум төгрөг нь нийт өсөлтийн 51.9 хувийг тус тус бүрдүүлж байна.

Тайлант улиралд хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 41.3 хувиар, өмнөх улирлаас 7.8 хувиар, хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар, өмнөх улирлаас 4 хувиар тус тус өслөө.

2017 оны эхний хагас жилийн байдлаар 2.5 тэрбум төгрөгөөс дээш хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 42 ББСБ-ын 178.3 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн 32.4 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 3.2

Хувьцаат капитал (интервалиар)		
Интерваль	ББСБ тоо	Дүн
5.0-13.9 тэрбум хүртэлх	11	82.5
2.5-4.9 тэрбум хүртэлх	31	95.8
1.0-2.4 тэрбум хүртэлх	115	150.8
0.8-0.9 тэрбум хүртэлх	241	195.2
0.2-0.7 тэрбум хүртэлх	38	16
0.2-с доош хүртэлх	97	9.2
Нийт	533	549.5

ББСБ-ууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх нь эрсдэл даах чадварыг сайжруулах, мөнгөн хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.


2017 оны тайлант улирлын байдлаар итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй 27 ББСБ-ын 21 нь 34.5 тэрбум төгрөгийг итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн нь салбарын нийт өр төлбөрийн 19.8 хувьтай тэнцэж байна. Нэр бүхий 3 ББСБ-ын итгэлцлийн үйлчилгээний өрийн үлдэгдэл нь харгалзан нийт итгэлцлээр татсан хөрөнгийн 19.9, 16.3, 10.4 хүртэлх хувийг эзэлж байна. Эдгээр 21 ББСБ-уудын нийт хөрөнгө нь салбарын нийт хөрөнгийн 24.6

хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын мөн үзүүлэлтийн 1.1 хувийг эзэлж байгаа ба харин тайлант улиралд итгэлцлийн үйлчилгээнээс орлого олоогүй байна.

2014 оны мөн үеийн байдлаар нийт итгэлцлээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн 21.8 хувийг валютаар татан төвлөрүүлсэн итгэлцлийн үйлчилгээний өглөг эзэлж байсан бол 2015 өсөлттэй байсан бол үүнээс хойш 4 улирал дараалан буурсан. Харин 2016 оны гуравдугаар улирлаас эхлэн мөн үзүүлэлт өсөх хандлага ажиглагдаж байна.

Дүрслэл 3.3

Итгэлцлийн үйлчилгээний өрийн өсөлт бууралт



Тайлант улирлын байдлаар нийт 35 ББСБ 16.3 тэрбум төгрөгийн төсөл хөтөлбөрийн зээлтэй байгаагаас 2.6 тэрбум төгрөг нь богино хугацаат, 13.7 тэрбум төгрөг нь урт хугацаат зээл байна.


Нийт төслийн зээлийн 10.4 тэрбум төгрөгийг гадаадын байгууллагаас, 4.4 тэрбум төгрөгийг дотоодын байгууллагаас үлдэх хэсгийг Засгийн газар болон бусад санхүүжилтээс авсан байна.

оноос эхлэн энэ үзүүлэлт буурсаар 2017 оны хоёрдугаар улиралд 16.5 хувьд хүрч, харин төгрөгөөр татан төвлөрүүлсэн итгэлцлийн үйлчилгээний өрийн хэмжээ өссөн байна.

Сүүлийн 14 улирлын дунджаас харахад 2015 оны мөн үед итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгө хамгийн өндөр

Дүрслэл 3.4

Төслийн зээлийн санхүүжилт (тэрбум төгрөгөөр)




Төслийн зээлийн санхүүжилт өмнөх оны мөн үеэс 3.7 тэрбум төгрөгөөр буурсан бууралтад дотоодын болон Засгийн газрын төслийн зээлийн эх үүсвэрээс 3.5 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн нь голчлон нөлөөлж байна.

Банк, санхүүгийн байгууллагад төлөх өр 92.1 тэрбум төгрөг байгаагаас 46.6 тэрбум төгрөг нь богино хугацаат, 45.4 тэрбум төгрөг нь урт хугацаат санхүүгийн өр төлбөр байна. Үүнээс 57.7 тэрбум төгрөгийг дотоодын банк, санхүүгийн байгууллагаас, 34.4 тэрбум төгрөгийг гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан өр төлбөр бүрдүүлж байна.

Дүрслэл 3.5

Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (тэрбум төгрөгөөр)



Тайлант улиралд банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг 9.8 тэрбум төгрөгөөр буурсан бууралтад валютын зээлээс 11.7 тэрбум төгрөг эргэн төлөгдсөн нь нөлөөлсөн бөгөөд төгрөгийн зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Мөн улиралд нэр бүхий 5 ББСБ-ын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 805.3 сая төгрөг, нэр бүхий 1 ББСБ-ын төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 2.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Нэр бүхий 5 ББСБ нийт 706.6 сая төгрөгийг хоёрдогч өглөгөөр, 7 ББСБ нийт 4.3 тэрбум төгрөгийг өрийн бичиг гаргах замаар татан төвлөрүүлсэн байна.

Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг нь салбарын нийт өр төлбөрийн 1.5 хувь, өрийн бичгээр татан төвлөрүүлсэн хөрөнгө нь мөн үзүүлэлтийн 2.6 хувьтай тус тус тэнцэж байна.


Хаалттай өрийн бичиг гаргасан нэр бүхий 3 ББСБ-ын 3.5 тэрбум төгрөгийн өглөг нь нийт хаалттай өрийн бичгийн 81.4 хувийг эзэлж байна.

Сүүлийн жилүүдэд хоёрдогч өглөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ буурч,

хаалттай өрийн бичгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өсөх хандлагатай байна.

Дүрслэл 3.6

Өр төлбөр 1 (тэрбум төгрөгөөр)



Хүснэгт 3.3

Өр төлбөр 2 (мянган төгрөгөөр)

Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг		
№	ББСБ нэр	Дүн
1	Мониполо	499,081.8
2	Шинэ төгрөг	300,690.6
3	Сайн финанс энд трансфер	3,465.6
4	Зэт пэй	1,794.0
5	Мөнгөн гүүр	250.0
НИЙТ		805,282.0
Төлбөр тооцооны үйлчилгээний өглөг		
1	Мобифинанс	2,720,010.3
Өрийн бичиг		
1	Ард кредит	1,535,900.0
2	Чоно финанс	1,254,029.0
3	Монголиан мортгэйж фонд	750,000.0
4	Есөн шижир инвест	400,000.0
5	Шүрэн капитал	200,000.0
6	Микро кредит	125,000.0
7	Роял финанс	49,000.0
НИЙТ		4,313,929.0
Хоёрдогч өглөг		
1	Марико	235,000.0
2	Алтан төгрөг	171,555.3
3	Ди Эй Эм Өү Эй	130,000.0
4	Актив моргэйж фонд	100,000.0
5	Роял финанс	70,000.0
НИЙТ		706,555.3

4

ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

4.1 ОРЛОГО

2017 оны эхний хагас жилийн байдлаар ББСБ-дын нийт орлого өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өслөө.

Хүснэгт 4.1

Орлогын бүрэлдэхүүн (тэрбум төгрөгөөр)

№	ОРЛОГЫН ТӨРӨЛ	2016-И		2017-И		Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	дүн	хувь	хувь
1	Хүүгийн орлого	65.5	74.3	8.8	13.4		
2	Хүүгийн бус орлого	17.2	12.0	(5.2)	(30.2)		
3	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1.5	3.2	1.7	113.1		
4	Ердийн бус орлого	-	-	-	-		
НИЙТ ОРЛОГО		84.2	89.5	5.3	6.3		

Нийт орлогын 83 хувийг хүүгийн орлого, 13.4 хувийг хүүгийн бус орлого, 3.5 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрдүүлж байна.

Хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 13.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны орлого 2.1 дахин өссөн бол хүүгийн бус орлого 30.2 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа.

2017 оны тайлант улирлын байдлаар нийт хүүгийн орлогын 70.7 тэрбум төгрөг буюу 95.2 хувийг хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого, 2.9 тэрбум төгрөг буюу 3.9 хувийг хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого, 2.2 тэрбум төгрөг буюу 3.2 хувийг банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого бүрдүүлж байна.

Хүүгийн бус орлогын 5 тэрбум төгрөг буюу 41.6 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 4.8 тэрбум төгрөг буюу 39.8 хувийг санхүүгийн үйлчилгээний орлого, 1.2 тэрбум төгрөг буюу 18.6 хувийг арилжааны орлого тус тус эзэлж байна. Харин үндсэн бус үйл ажиллагааны орлогын 1.8 тэрбум төгрөг буюу 57.9 хувийг бусад орлого, 0.7 тэрбум төгрөг буюу 20.8 хувийг тэнцлийн гадуурх тооцооны эргэн төлөлт, 0.6 тэрбум төгрөг буюу 19.4 хувийг алдангийн орлогоос бүрдсэн байна.

Нийт орлогод эзлэх хүүгийн орлогын хэмжээ 2016 оны 3 дугаар улирлаас эхлэн буурч байсан бол 2017 оноос эхлэн өссөөр 83 хувьд хүрлээ.


ББСБ-уудын 2017 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

ББСБ-дын нийт орлого 2015, 2016 оны мөн үеэс харгалзан 12.3 тэрбум төгрөгөөр буюу 15.9 хувиар, 5.3 тэрбум төгрөгөөр буюу 6.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Иргэдэд олгосон зээлийн хэмжээ өндөр байгаатай уялдуулан нийт хүүгийн орлогын 82.6 хувь нь иргэдийн хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого байна.

Дүрслэл 4.1

Орлогын бүтэц (хувиар)



4.2 ЗАРДАЛ

2017 оны хоёрдугаар улиралд нийт зардал өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өслөө.

Хүснэгт 4.2

Зардлын бүрэлдэхүүн (тэрбум төгрөгөөр)

№	ЗАРДЛЫН ТӨРӨЛ	2016-И		2017-И		Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	дүн	хувь	хувь
1	Хүүгийн зардал	7.6	6.9	(0.7)	(9.2)		
2	Хүүгийн бус зардал	37.8	40.0	2.2	5.8		
3	Болзошгүй эрсдэлийн зардал	9.9	10.2	0.3	3.0		
4	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.6	0.8	0.2	33.3		
5	Орлогын татварын зардал	3.2	3.5	0.3	9.4		
НИЙТ ЗАРДАЛ		59.1	61.4	2.3	3.9		

Нийт зардлын 65.1 хувийг хүүгийн бус зардал, 16.6 хувийг болзошгүй эрсдэлийн сангийн зардал, 11.2 хувийг хүүгийн зардал, 5.7 хувийг орлогын албан татварын зардал бүрдүүлж байна.

Нийт зардал өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар, үүний дотор хүүгийн бус зардал 5.8 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 3 хувиар, орлогын татварын зардал 9.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 33.3 хувиар тус тус өссөн бол хүүгийн зардал 9.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Хүүгийн зардлын 53.1 хувийг бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал, 32.7 хувийг банкны зээлийн хүүгийн зардал, 12.4 хувийг төслийн зээлийн хүүгийн зардал, 3.9 хувийг өрийн бичгийн хүүгийн зардал эзэлж байна.

Хүүгийн бус зардлын 43.2 хувийг бусад зардал (үүний дотор 8.7 хувийг түрээсийн зардал, 6.5 хувийг итгэлцлийн үйлчилгээтэй холбогдон гарсан зардал, 4.1 хувийг элэгдлийн зардал), 38.8 хувийг боловсон хүчний зардал, 18 хувийг арилжааны болон ханшийн тэгшитгэлийн зардал бүрдүүлж байна.

Нийт болзошгүй эрсдэлийн зардлын 85.4 хувь нь зээлийн эрсдэлийн сангийн зардал, 9.1 хувь нь өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал, 5.4 хувь нь авлагын эрсдэлийн зардал байна.

Дүрслэл 4.2

Зардлын бүтэц (тэрбум төгрөгөөр)



Салбарын хэмжээнд ББСБ-ууд 100 төгрөгийн орлого олохын тулд 69 төгрөгийн зардал гаргасан байх бөгөөд үндсэн үйл ажиллагааны зардлын ханшийн тэгшитгэлийн зардал, ажилтнуудын цалингийн зардал,

түрээсийн зардал харьцангуй өндөр байгаа нь нийт зардал өсөхөд нөлөөлөв.

4.3 АШИГТ АЖИЛЛАГАА

ББСБ-уудын ашигт ажиллагаа өнгөрсөн оны мөн үеэс 3.1 тэрбум төгрөгөөр буюу 12.4 хувиар өсч, 28.1 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 4.3

Ашигт ажиллагаа (тэрбум төгрөгөөр)


№	Үзүүлэлт	2016-II	2017-II	Өөрчлөлт	
		дүн	дүн	дүн	хувь
1	Нийт орлого	84.2	89.5	5.3	6.3
2	Нийт зарлага	59.2	61.4	2.2	3.7
ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ		25.0	28.1	3.1	12.4

Салбарын хэмжээнд нийт 533 ББСБ үйл ажиллагаа эрхэлж байгаагаас 76.7 хувь буюу 409 ББСБ 32.4 тэрбум төгрөгийн ашигтай, 5.1 хувь буюу 27 ББСБ үйл ажиллагаа эрхлээгүй, 18.2 хувь буюу 97 ББСБ 4.3 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Сүүлийн 5 жилийн дүн мэдээнээс харахад ББСБ-уудын ашигт ажиллагааны үзүүлэлт 2013 онд өмнөх оны мөн үеэс 56.6 хувиар өсөөд байсан бол 2014 оноос эхлэн өсөлтийн хурдац нь саарсаар 2017 оны тайлант улиралд 12.4 хувьд хүрсэн байна.

Дүрслэл 3.6

Ашигт ажиллагаа (тэрбум төгрөгөөр)



ББСБ-ын салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтийг илэрхийлдэг өөрийн хөрөнгийн өгөөж 4.7 хувь, активын өгөөж 3.7 хувь байна.



САЛБАРЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

5.1 ОРОН НУТАГ ДАХЬ БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Хөдөө орон нутаг дахь ББСБ-уудын нийт актив 2017 оны хоёрдугаар улирлын эцэст 21.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.3 тэрбум төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөнөөр салбарын нийт активын 2.3 хувийг бүрдүүлж байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдэл нь салбарын мөн үзүүлэлтийн 3.3 хувь, өөрийн хөрөнгө нь 2.9 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3.2 хувьтай тус тус тэнцэж байна.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 57 ББСБ зээлийн үйл ажиллагаа, 2 ББСБ гадаад валютын арилжаа дагнан эрхэлж байгаа бол 7 ББСБ зээлийн үйл ажиллагааг бусад үйл ажиллагаатай хавсран эрхэлж байна.

Хүснэгт 5.1

Ашигт ажиллагаа (тэрбум төгрөгөөр)


Үндсэн үзүүлэлтүүд	2016-II	2017-II	Өсөлт бууралт
ББСБ тоо	53	66	13
Салбарын ББСБ тоонд эзлэх хувь	10.6%	12.4%	1.8%
Нийт актив	16.3	21.6	5.3
ББСБ-ын нийт активт эзлэх хувь	2.4%	2.5%	0.1%
Нийт зээл	12.8	18.1	5.3
ББСБ-ын нийт зээлд эзлэх хувь	3.1%	3.3%	0.2%
Чанаргүй зээл	0.5	3.2	2.7
ББСБ-ын нийт чанаргүй зээлд эзлэх хувь	4.2%	4.4%	0.2%
Нийт өөрийн хөрөнгө	14.3	19.5	5.2
ББСБ-ын нийт өөрийн хөрөнгөд эзлэх хувь	2.8%	2.9%	0.1%
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	8.3	17.4	9.1
ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь	2.1%	3.2%	1.1%

Хүн амын суурьшил, орлого болон үйлдвэрлэл эрхлэлтээс хамаарч аймгууд дахь банк бус санхүүгийн салбарын активын хэмжээ харилцан адилгүй байна. Орон нутаг дахь ББСБ-уудын активын хэмжээг байршлаар нь авч үзвэл Дархан-Уул, Орхон, Төв аймгууд дахь активын хэмжээ хамгийн их байгаа бол Ховд, Архангай, Булган аймгуудад хамгийн бага байна.

ББСБ-уудын 2017 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Дүрслэл 5.1

Аймгуудын активын төвлөрөл (тэрбум төгрөгөөр)



Нийт орон нутаг дахь банк бус санхүүгийн байгууллагуудын активын 71.3 хувийг Дархан-Уул, Орхон, Төв аймгуудад үйл ажиллагаа явуулж байгаа ББСБ-ууд бүрдүүлж байна.

2017 оны хоёрдугаар улирлын байдлаар орон нутаг дахь банк бус санхүүгийн байгууллагуудын активын 83.8 хувийг нийт зээлийн өрийн үлдэгдэл, 20.2 хувийг мөнгөн хөрөнгө, 3.6 хувийг хуримтлуулсан хүүгийн авлага, 3.7 хувийг үндсэн хөрөнгө бүрдүүлж байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 14.1 тэрбум төгрөг буюу 77.8 хувь нь хэвийн, 0.8 тэрбум төгрөг буюу 4.4 хувь нь хугацаа хэтэрсэн, 3.2 тэрбум төгрөг буюу 17.8 хувь нь чанаргүй зээлийн ангилалд шилжсэн байна.

Нийт зээлийн багцын 15 тэрбум төгрөг буюу 82.9 хувь нь Дархан-Уул, Төв, Орхон аймгуудад төвлөрсөн байх ба үүний 3 тэрбум төгрөг буюу 20 хувь нь чанаргүйдсэн байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өсөлттэй байгаа хэдий ч чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өссөн явдал нь нэр бүхий 5 ББСБ-ын зээлийн чанар муудсантай холбоотой.

Нийт пассивын бүтцийг авч үзвэл 19.5 тэрбум төгрөг буюу 90.3 хувийг өөрийн хөрөнгө 2.1 тэрбум төгрөг буюу 9.7 хувийг өр төлбөр бүрдүүлж байна. Өр төлбөрийн 55.6 хувь нь итгэлцлийн үйлчилгээний өр, 11.6 хувь нь банк, санхүүгийн байгууллагад төлөх өр, 13.5 хувийг бусад пассив бүрдүүлж байна.

Харин нийт өөрийн хөрөнгийн 88.9 хувь нь хувь нийлүүлсэн хөрөнгө, 7.1 хувь нь хуримтлагдсан ашиг бүрдүүлж байна. Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд тайлант хугацаанд 1.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

5.2 ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ББСБ

Тайлант улиралд гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 32 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын 6 хувь, тэдгээрийн актив нь салбарын 13.5 хувь, зээлийн өрийн үлдэгдэл нь салбарын 15.2 хувь, өөрийн хөрөнгө нь салбарын 7.9 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө нь салбарын 8.2 хувьтай тус тус тэнцэж байна.

Хүснэгт 5.2

Санхүүгийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2016-И	2017-И	өсөлт
			бууралт
ББСБ тоо	30	32	2.0
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	6.0%	6.0%	0.0%
Нийт актив	110.6	115.7	5.1
ББСБ-ын нийт активт эзлэх хувь	16.3%	13.5%	(2.8%)
Нийт зээлийн өрийн үлдэгдэл	65.9	84.3	18.4
Үүнээс: Чанаргүй зээл	9.6	15.1	5.5
Нийт ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	14.5%	15.2%	0.7%
Нийт өөрийн хөрөнгө	59.7	53.9	(5.8)
ББСБ-ын нийт эздийн өмчид эзлэх хувь	11.8%	7.9%	(3.9%)
Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	51.0	44.9	(6.1)
ББСБ-ын нийт хувь хөрөнгөд эзлэх хувь	13.1%	8.2%	(4.9%)

Гадаадын хөрөнгө оруулагчдыг харьяаллаар нь авч үзвэл Япон улсын хөрөнгө оруулалттай 12, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 8, Хонг Конгийн хөрөнгө оруулалттай 3, БНХАУ хөрөнгө оруулалттай 2, Орос, Сичель, Франц, Англи, АНУ, Люксембург, Малайз, Швейцарийн хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

ББСБ-уудын 2017 оны хоёрдугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-уудын тоо өссөн хэдий ч өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 3.9, 4.9 хувиар тус тус буурлаа.

Нийт зээлийн үлдэгдлийн 51.6 тэрбум төгрөг буюу 51.6 хувь нь нэр бүхий 3 ББСБ-д төвлөрсөн байх ба эдгээр ББСБ-дын нийт хөрөнгө нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-дын нийт хөрөнгийн 52.4 хувийг бүрдүүлж байна.

Нийт өр төлбөрийн 71.4 хувийг банк, санхүүгийн байгууллагад төлөх өр, 14.6 хувийг төсөл хөтөлбөрийн зээл, 5.2 хувийг итгэлцлийн үйлчилгээний өр, үлдэх хэсгийг бусад өр төлбөр эзэлж байна.

Нийт өөрийн хөрөнгийн 83.3 хувь нь хувь нийлүүлсэн хөрөнгө, 14.4 хувь нь хуримтлагдсан ашиг байгаагаас тайлант улиралд 1.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна.

5.3 ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА ЭРХЛЭН ЯВУУЛЖ БУЙ ББСБ

Тайлант хугацаанд Хорооноос тусгай зөвшөөрөл авсан нийт 533 ББСБ-ын 27.6 хувь буюу 147 ББСБ гадаад валютын арилжаа эрхэлж байгаагийн 36.1 хувь буюу 53 компани нь тухайн үйл ажиллагааг дагнан эрхэлж байна.

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 0.1 функтээр буурсан нь ББСБ-уудын тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлттэй шууд хамааралтай.

Гадаад валютын арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-уудын нийт хөрөнгө салбарын мөн үзүүлэлтийн 1.6 хувь, өөрийн хөрөнгө 2 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 2.3 хувьтай тус тус тэнцэж байна.

Хүснэгт 5.3

Санхүүгийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлтүүд	2016-И	2017-И	өсөлт
			бууралт
ББСБ-ын тоо	51	53	2
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь	10.2%	9.9%	(0.3%)
Нийт актив	10.2	13.5	3.3
ББСБ-ын нийт активт эзлэх хувь	1.5%	1.6%	0.1%
Өөрийн хөрөнгө	10.1	13.4	3.3
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь	2.0%	2.0%	-

Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	9.5	12.5	3
ББСБ-ын нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь	2.4%	2.3%	(0.1)

Нэгтгэлийн дүнгээр гадаад валют арилжаа дагнан эрхэлж буй ББСБ-ууд нийт 807.4 сая төгрөгийн орлого олсноос арилжааны орлого 96.5 хувь, ханшийн тэгштгэлийн орлого 1.1 хувийг эзэлж байна. Харин тайлант улиралд нийт 706.1 сая төгрөгийн зардал гаргаснаас 54.4 хувийг боловсон хүчний зардал, 32.8 хувийг бусад зардал эзэлж байгаа ба тайлант улиралд 101.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Хүснэгт 5.4

Санхүүгийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөгөөр)

Худалдаж авсан	
АНУ-ын доллар	250.5
ОХУ-ын рубль	9.8
БНХАУ-ын юань	214.4
БНСУ-ын вон	15.2
Евро	36.0
Японы иен	11.4
Английн фунт	2.5
Австралийн доллар	0.5
Сингапурын доллар	0.5
Хонконг доллар	1.1
Канадын доллар	0.1
Швейцарь франк	0.8
БНАСАУ-ын вон	0.1

НИЙТ	543.0
Худалдсан	
АНУ-ын доллар	252.5
ОХУ-ын рубль	10.4
БНХАУ-ын юань	207.3
БНСУ-ын вон	15.2
Евро	35.9
Японы иен	11.2
Английн фунт	2.4
Австралийн доллар	0.7
Сингапурын доллар	0.5
Хонконг доллар	1.0
Канадын доллар	0.1
Швейцарь франк	0.8
БНАСАУ-ын вон	0.1
НИЙТ	538.3

Валют арилжааны мэдээ ирүүлсэн ББСБ-дын тоо мэдээнээс үзэхэд 2017 оны эхний хагас жилд нийт 543.0 тэрбум төгрөгийн валют худалдан авч, 538.3 тэрбум төгрөгийн валют худалдсан байна. Нийт худалдаж авсан валютын 46.1 хувь буюу 250.5 тэрбум төгрөгт ам.доллар, 39.5 хувь буюу 214.4 тэрбум төгрөгт юань, 6.6 хувь буюу 36.0 тэрбум төгрөгт евро тус тус худалдаж авсан бол нийт зарсан валютын 46.9 хувь буюу 252.5 тэрбум төгрөгт ам.доллар, 38.5 хувь буюу 207.3 тэрбум төгрөгт юань, 6.7 хувь буюу 35.9 тэрбум төгрөгт евро тус тус зарсан байна.

6

САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч ББСБ-дын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан мэдээг Хорооны 2016 оны 147 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу тооцож үзэхэд системийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 6.1

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	445	83.5
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	56	10.5
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	23	4.3
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	6	1.1
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	0.6
НИЙТ		533	100

2017 оны нэгдүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 533 ББСБ-ын 83.5 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 10.5 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 4.3 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 1.1 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 0.6 хувь нь 4 харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

ЖУРМЫН 3.2-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 6.2

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	46	86.8
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	2	3.8
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	7.5
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	1	1.9
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	-	-
НИЙТ		53	100

Журмын 3.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 6 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 90.6 хувь;

2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 40 хувиас доошгүй байх шаардлагыг 48 ББСБ хангасан буюу биелэлт 90.6 хувь;

3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 52 ББСБ хангасан буюу биелэлт 98.1 хувь;

4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг бүрэн;

5) үндсэн хөрөнгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 15 хувиас ихгүй байх шаардлагыг 51 ББСБ хангасан буюу 96.2 хувь;

6) өөрийн бичгийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

Эдгээр ББСБ-уудын хувьд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, үндсэн хөрөнгийн зохистой харьцаа үзүүлэлт хамгийн ихээр алдагдсан байна.

ЖУРМЫН 3.3-Т ЗААСАН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 6.3

№	Үзүүлэлт	ББСБ-ын тоо	Эзлэх хувь
1	Зохистой харьцааг хангаж ажилласан ББСБ-ын тоо	358	81.9
2	1 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	48	11.1
3	2 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	19	4.4
4	3 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	4	0.9
5	4 Зохистой харьцааг хангаж ажиллаагүй ББСБ-ын тоо	3	0.7
НИЙТ		432	100

Журмын 3.3-т заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдүүдийн хувьд тооцвол зохих зохистой харьцааны 14 шалгуур үзүүлэлтүүдийн хэрэгжилт:

1) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 423 ББСБ хангасан буюу биелэлт 97.9 хувь;

2) өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 30 хувиас доошгүй байх шаардлагыг 421 ББСБ хангасан буюу биелэлт 97.5 хувь;

3) нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа 20 хувиас доошгүй байх шаардлагыг 430 ББСБ хангасан буюу биелэлт 99.5 хувь;

4) төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 8 хувиас доошгүй байх шаардлагыг 417 ББСБ хангасан буюу биелэлт 96.5 хувь;

5) активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг бүрэн;

6) нэг этгээдэд олгох зээлийн төвлөрлийн эрсдэлийн үзүүлэлт 30 хувиас ихгүй байх шаардлагыг 415 ББСБ хангасан буюу биелэлт 96.1 хувь;

7) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээ 10 хувиас ихгүй байх шаардлагыг 422 ББСБ хангасан буюу биелэлт 97.7 хувь;

8) нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн төвлөрлийн үзүүлэлт 25 хувиас ихгүй байх шаардлагыг 429 ББСБ хангасан буюу биелэлт 99.3 хувь;

9) үнэт цаасны эзэмшлийн дүн нь өөрийн хөрөнгийн 20 хувиас ихгүй байх шаардлагыг 430 ББСБ хангасан буюу биелэлт 99.5 хувь;

10) нэг компаниас худалдан авах үнэт цаасны эзэмшлийн дүн өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байх шаардлага бүрэн;

11) ББСБ-аас гаргах төлбөрийн баталгааны зохистой харьцаа 70 хувиас ихгүй байх шаардлагыг 431 ББСБ хангасан буюу биелэлт 99.8 хувь;

12) гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа (+/-40) хувиас хэтрэхгүй байх шаардлага 410 ББСБ хангасан буюу биелэлт 94.9 хувь;

13) цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн зохистой харьцаа 15 хувиас ихгүй байх шаардлагыг 414 ББСБ хангасан буюу биелэлт 95.8 хувь;

14) өрийн бичгийн зохистой харьцаа 50 хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

